



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталж, нийт 489,361,441 (дөрвөн зуун наян есөн сая гурван зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун дөчин нэг) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн холбогдох хууль, журмын дагуу бүртгэж авахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д үүрэг болгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

2

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2026 оны 01 дүгээр сарын 28 өдрийн
...2026 оны 01 дүгээр сарын... тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

2026 оны 01 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

№	Бүртгэх хөрөнгийн жагсаалт	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт өртөг
1	2	3	4	5	6	7
1	Авто зам, авто зогсоол	2024	1260	м2	120,214.71	151,470,533
2	Явган зам талбай	2024	1380		39,408.62	54,383,902
3	Налуулга зүлэг /газрын налуу хэсэгт хийгдсэн ногоон байгууламж/	2024	190		132,008.02	25,081,524
4	Хайрган хучилттай талбай	2024	50		49,903.04	2,495,152
5	Бетон суурьтай модон шонтой, модон хашаа 1,2м	2024	165	у/м	550,397.19	90,815,537
6	Том модон ширээ сандал /1,6м*2.03м/	2024	6	ш	679,390.17	4,076,341
7	Амралтын бүсийн сандал /хагас дугуй хэлбэртэй/	2024	14	ш	288,896.93	4,044,557
8	Жижиг сандал /2,2м*0,3м/	2024	27	ш	155,935.52	4,210,259
9	Амралтын бүсийн модон хаалт	2024	106	у/м	30,825.30	3,267,482
10	Модон шонтой олс татлага	2024	1260	у/м	35,307.73	44,487,743
11	Төмөр торон хашаа /1,5м өндөр/	2024	420	у/м	234,359.08	98,430,812
Үндсэн хөрөнгийн үнэ						482,763,842
1	Нэгдсэн мэдээллийн самбар	2024	1	ш	3,108,918.00	3,108,918
2	Маршрутын самбар	2024	1	ш	1,917,674.00	1,917,674
3	Мэдээллийн самбар	2024	1	ш	479,458.00	479,458
4	Хогийн сав /0,72м-0,8м*0,4м/		7	ш	155,935.57	1,091,549
Бараа материалын үнэ						6,597,599
Бүртгэх хөрөнгийн нийт үнэ						489,361,441



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 1102

Улаанбаатар хот

Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/133 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/107 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дотоод, гадаадын иргэд, жуулчдад Улаанбаатар хотын аялал жуулчлалын талаарх хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөө өгөх жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.


3.Арга хэмжээг үргэлжлүүлэхэд шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль журмын дагуу гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс (Н.Алтанзаяа)-т даалгасугай.

ДАРГА

D. Batuy

Д.БАТСҮХ





НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А03

Улаанбаатар хот

Гадаад сурталчилгааны талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн засаг даргын 2026 оны А/108 дугаар захирамж, 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн арга хэмжээний үеэр ашиглах зорилгоор сурталчилгааны материал хэвлүүлж, тараах ажлыг зохион байгуулсугай.

2.Гадаад сурталчилгааны талаар авах зарим арга хэмжээний төсвийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль журмын дагуу гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс (Н.Алтанзаяа)-т даалгасугай.

ДАРГА *D. Bat* Д.БАТСҮХ



D:\NAJG 2026\Tushaal\A tushaal tusul.docx
1726010019



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

「Улаанбаатарын өвлийн наадам-2026」 олон
улсын арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны 109 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам-2026” олон улсын арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 31, 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Улаанбаатарын өвлийн наадам 2026” олон улсын арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль журамд нийцүүлэх гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-г даалгасугай.

ДАРГА



D. Batcuy

Д.БАТСҮХ

